



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 6/15

Улаанбаатар хот

**Б.Нямгэрэлийг үүрэгт ажлаас чөлөөлөх
тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, 39.2 дахь заалт, төвийн дотоод журмын 13.2, төвийн даргын 2017 оны А/04 тоот тушаалаар баталсан "Нийгмийн хамгааллын тусгай төвийн ажилтнуудын ажил хүлээлцэх журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төвийн үйлчлэгч Б.Нямгэрэлийг өөрийн хүсэлтийн дагуу 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2.Хариуцаж байсан ажил үүргээ зохих журмын дагуу бүрэн хүлээлгэн өгч, төлбөр тооцоогоо дуусгахыг Б.Нямгэрэлд үүрэг болгосугай.

3.Б.Нямгэрэлтэй холбогдох тооцоог зохих журмын дагуу хийж дуусгахыг нягтлан бодогч /Б.Энхдолгор /-д даалгасугай.

ДАРГА



Г.ЦЭРЭНДУЛАМ

3180602-2